

Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид

1940-10-3-анд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

Мөн дүр-мэнд хотын захиргааны дотоод зохион байгуулалтыг :

- Санхүүгийн хэлтэс
- Ардын гэгээрлийн хэлтэс
- Эрүүлийг хамгаалах хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Хот сайжруулах хэлтэс
- Аж ахуйн хэлтэс гэж тус тус байхаар тогтоожээ.

1953 онд Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалт, орон тоо нь: -

Ерөнхий хэлтэс 1- 42

- Санхүүгийн хэлтэс 1- 26
- Гэгээрлийн хэлтэс 1- 9
- Төлөвлөгөөний комисс 1-19
- Эрүүлийг хамгаалах хэлтэс 1-8
- Цэргийн хэлтэс 1- 2

- Хот сайжруулах 1- 23 Бүгд 7-123 тус тус байсан байна.

1952 оны 11 сарын 01-эс Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа - хэмээх болсон.

Бөгөөд дотоод бүтцийг нь : Бүгд 7-123 тус тус байсан байна

Мөн хурлаар Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчдийн захиргааны дүрмийг шинэчлэн баталсан.

Эл дүрмээр хотыг гүйцэтгэх захиргаа нь үндсэн хуульд заагдсан заалтыг удирдлага болгохоос гадна нам засгаас гаргасан тогтоол, удирдамж, хотын намын хороо, гүйцэтгэх захиргааны өдөр тутмын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелүүлэх ажлыг шууд зохион байгуулах үүрэг хүлээнэ.